50

БАТЛАВ:
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ТАВИНБЭХ

ЧОЙР – МАНДАЛГОВЬ ЧИГЛЭЛИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ, 220/110/35 кВ-ЫН "ЧОЙР", "МАНДАЛ" ДЭД СТАНЦУУДЫН ӨРГӨТГӨЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.11.13 2024/Ц-28 Улаанбаатар хот

1. Үндэслэл	2024 оны төсвийн тухай хууль;
2. Үйлдвэрлэл, аж ахуйн үндсэн чиглэл	Цахилгаан эрчим хүч дамжуулах;
3. Байршил	Говьсүмбэр, Дундговь аймгууд
4. Хүч чадал	Цахилгаан эрчим хүч дамжуулах чадал, хүчдэлийг тооцоогоор сонгох;
5. Үйлдвэрлэлийн түүхий эд, материал, ажиллах хүчний хангамж эх үүсвэр	Мэргэшсэн монгол ажиллагсад
6. Технологийн горимын үндсэн шаардлага	Олон улсын түвшинд мөрдөгдөж байгаа байгаль орчинд хор нөлөөгүй технологи;
7. Бүтээгдэхүүний чанар	Хэрэглэгчдийн шаардлага хангасан цахилгаан эрчим хүчийг хамгийн бага алдагдалтайгаар дамжуулах;
8. Стандартын шаардлага	Зураг төслийг Монгол улсын цахилгаан байгууламжийн дүрэм (2003), эрчим хүчний тоног төхөөрөмж байгууламжийн техник ашиглалтын дүрэм, цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, Барилгын норм ба дүрмийн цахилгаан сантехникийн ажил 3.05.06.90 ба 3-07-6-гийн заалтын дагуу гүйцэтгэх;
9. Ажиллах горим	Зэрэгцээ горимд 24 цагийн тасралтгүй ажиллагаатай байх;
10. Барилга байгууламжийн бүрэлдэхүүн	Стратегийн ач холбогдол бүхий орд газрууд, Сайншандын аж үйлдвэрийн паркийг Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд холбох;
11. Барилгын үндсэн бүтээц, материал	Дамжуулах шугаманд суурилагдах тоног төхөөрөмж нь Монгол орны цаг уурын нөхцөл, далайн түвшний өндөрлөг, IEC стандартыг хангасан, тэргүүний дэвшилтэт технологитой байх;

Бүртгэлийн дугаар .....
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭГ ... ТҮГ ХУУЛ...
Хуулийн ... сэг...
2025 03 17

12. Захиалагч байгууллага	Эрчим хүчний яам;
13. ТЭЗҮ, Зургийн байгууллага	"Эрчим хүчний барилга угсралтын зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл" авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх;
14. Барилга угсралтын зураг төслийн байгууллага	Тендер шалгаруулалт;
15. ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах хугацаа	..... сар.
16. Онцгой нөхцөл	

16.1. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, одоогийн горим, үйл ажиллагаа, онцлог шинж чанарын талаар үнэлэлт дүгнэлт өгөх.

- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний өвлийн их болон зуны бага горимын тооцоог хийж чадлын урсгал, хүчдэлийн балансын шинжилгээг хийх;
- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний горим түүний онцлог шинж чанар, тогтворжилтын тооцоо болон аваарын горимын тооцоог хийх, дүгнэлт гаргах.

16.2. Цахилгаан ачааллын прогноз гаргах.

- Бүс нутгийн хөгжилд нөлөөтэй томоохон төсөл хөтөлбөрүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа, бүсийн хөгжлийн төлөвлөгөөг судалж гаргах;
- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний эрчим хүчний хэрэглээний өсөлтийг бүс нутаг, улс орны хэмжээний үйлдвэрлэл, барилга, уул уурхай, ахуйн хэрэглээний цахилгаан ачааллаар эдийн засгийн өсөлтийн хурд, инфляц, хөгжлийн индекс үзүүлэлтүүдэд тохирсон, тухайн улсын онцлогийг тусгасан аргачлалаар тооцон төлөвлөж олон жилийн графикийг гаргах.

16.3 Монгол орны тухайн бүс нутгийн байгаль, цаг уур, газар нутгийн онцлогтой уялдуулах.

- Дэлгэрэнгүй судалгааг хийх, нэгтгэж хавсаргах, түүнтэй уялдуулан цахилгаан тоноглол, төхөөрөмж, материалыг сонгох;
- Олон жилийн судалгааны үндсэн дээр дүгнэлт гарган шийдэл гаргах ба удаа дараа тохиолдож байсан байгалийн гамшгийг тооцож, зураг төслийн шатанд анхаарах зөвлөмж, мөн түүнчлэн байгаль, экологийн талаас зөвлөмж боловсруулж өгөх;
- Байгаль экологийн судалгаатай яаж уялдуулсан талаар дэлгэрэнгүй тайлбар хийх.

16.4. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний тулгуур хэсэг болох Чойр-Мандалговь чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг системийн эх үүсвэртэй уялдуулан төлөвлөх.

- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний эх үүсвэрүүд, ДЦС-2 болон ДЦС-3-ын өргөтгөл, Нялга – Чойрын сав газар шинээр баригдаж буй 600 МВт-ын Бөөрөлжүүтийн ДЦС, шинээр баригдах 660 МВт-ын "Баян" ДЦС, 300 МВт-ын "Баяас повер" нүүрс хийн цахилгаан станц болон бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн үйлдвэрлэлийг судалж, тооцоолох замаар Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний үйлдвэрлэл болон хэрэглээний балансыг горимтой уялдуулан нарийвчлан гаргах;

16.5. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний цахилгаан дамжуулах шугамыг өргөтгөх хувилбаруудыг тооцож, цахилгаан хангамжийн хэтийн төлөвийн схемийн шийдэл боловсруулах. Үүнд:

- Хүчин чадал, нэвтрүүлэх чадварыг нь өргөтгөх шаардлагатай шугам, дэд станцуудыг тодорхойлж, техникийн шийдэл боловсруулах. Үүнд:
  - Баян - Сонгино чиглэлийн 330 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам;
  - Баян – Городок чиглэлийн 330 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам,;
  - 220/110/35 кВ-ын "Сонгино", "Городок", "Улаанбаатар", "Багануур" дэд станцуудыг 330 кВ-ын хүчдэлийн түвшинд шилжүүлэх ажил,
  - Мандалговь – Арвайхээр чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц
  - Багануур – Чойр, Чойр – Сайншанд, Сайншанд – Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц
  - Сонгино – Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц
  - Багануур – Бөөрөлжүүт чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц,
  - Бөөрөлжүүт – Сэргэлэн чиглэлийн 220 кВ-ын ЦДАШ, дэд станц,
- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний статик болон динамик тогтворжилтын тооцооны үр дүнгээр схемийг оновчлох,

16.6 Бүс нутгийн ашигт малтмалын орд газрууд болон төвийн бүсийн нэгдсэн сүлжээний хэтийн төлөвийн схемийн шийдэл дээр системийн хэмжээнд тогтсон горимын тооцоог ачааллын бүх хувилбар дээр тооцож үзсэний үндсэн дээр дараах шийдлүүдийг тодорхойлж гаргах. Үүнд:

- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний үйл ажиллагааны шинэ горимыг тооцоолон боловсруулж, урьдчилсан байдлаар чадлын урсгал, тогтворжилтын тооцооны үндсэн дээр үр дүнг оруулах;
- Шугамын нэвтрүүлэх чадвар, шугамын алдагдлыг тодорхойлох, хэвийн горимыг хангах, дамжуулах чадварыг дээшлүүлэх техникийн арга хэмжээнүүдийг төлөвлөх;
- Орчин үеийн, стандартад нийцсэн, тэргүүний дэвшилтэт технологитой тоног төхөөрөмжийг судлан үзэж тооцоогоор сонгох.

17. Тусгай нөхцөл

- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох.
- Эрсдэлийн үнэлгээг өнөөгийн болон ирээдүйн нөхцөл байдалд тулгуурлан үнэн зөв хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гаргах;
- Теслийн орлого болон зардлын эрсдэлийг тодорхойлох, холбогдох мэдрэмжийн шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ боловсруулах.
- Цаашид шинээр баригдах дамжуулах болон түгээх сүлжээний техникийн шийдэл, тоног, төхөөрөмж, алсын удирдлага, шугам, дэд станцуудын хөрөнгө оруулалтыг тодорхойлох.
- Техник, эдийн засгийн үндэслэл, зураг теслийг боловсруулах явцад тухайн төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагууд болон "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК болон "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-тай зөвшилцөж ажиллах,

- Шинэ шугам, дэд станцын зураг төслийн болон барилга угсралтын ажлын эдийн засгийн хөрөнгө оруулалтын тооцоог гаргаж, хамгийн оновчтой хувилбарыг судлан Техник, эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах,
- Сонгосон хамгийн оновчтой хувилбараар төслийн техникийн нөхцөл, зургийн даалгаврыг Эрчим хүчний яамнаас авч зураг төслийг батлагдсан даалгаврын дагуу гүйцэтгэх, эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулах,
- Батлагдсан Техник, эдийн засгийн үндэслэл болон зураг төслийг Эрчим хүчний яаманд хүлээлгэн өгөх,

18. Дүгнэлт гаргаж, санал зөвлөмж өгөх

ХЯНАСАН:
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА — Б.ЕРЭН-ӨЛЗИЙ

БОЛОВСРУУЛСАН:
СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН — Д.ДУЛМАА